



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 09 өдөр

Дугаар 419

Улаанбаатар хот

Банкны баталгааны тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, 9 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 6.10.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компани болон “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн хооронд 2018 онд байгуулсан DQYT-2018-JSGC-3196 дугаар бүхий “Барилгын ажил гүйцэтгэх гэрээ”-г хэрэгжүүлэх зорилгоор “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын барилга угсралтын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай банкны урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргахыг зөвшөөрсүгэй.

2. Урьдчилгаа төлбөрийн баталгааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гаргах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг “Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА



0002257